



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР**

Дуурсах 3 дугаар баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64103
Утас 7044 2878, Факс 7044 2891

2022.07.01 № 360
танай 2022.02.24-ны № 1/148 -Т

Г БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ Г
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг хүргүүлж байна.

Хавсралт **1** хуудастай

ДАРГА *[Signature]* Н.ЭНХЖАРГАЛ



642208620

Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт

22.06.30

| д/д | Өгөгдсөн зөвлөмж, акт, албан шаардлага | Биелэлт | Хэрэгжилтийн хувь /тайлбар/ |
|--------------------------|--|---|-----------------------------|
| 1.Зөвлөмж | | | |
| 1.1 | Эрүүл мэндийн яамнаас ирсэн хөрөнгө оруулалтыг анхан шатны баримттай нь тулгаж, бүрэн хүлээж авах тал дээр анхаарч ажиллах | Эрүүл мэндийн яамнаас олгосон бараа материал болон үндсэн хөрөнгийг хоорондын тооцоогоор тулган баталгаажуулж, санхүүгийн програмын дансны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, дамжуулах хөрөнгийг тусад нь бүртгэж, хөрөнгө шилжүүлэх шийдвэрээр хуваарилан ажиллаж байна. | 100 |
| 2.Төлбөрийн акт | | | |
| 2.1 | Аймгийн Засаг даргын захирамжаар малчдын өвөлжилтийн байдал хүндэрсэнтэй холбоотойгоор төл мал худалдан авах уриалгын хүрээнд зориулалт бусаар зарцуулсан 2944.4 мянган төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнаар төлүүлэх. | Байгууллагын удирдлагын зөвлөлөөр асуудлыг хэлэлцүүлж, тодорхой шийдвэр гаргуулж, 3 дугаар улиралд багтаан төлбөрийн актыг барагдуулахаар төлөвлөсөн. | Хүлээгдэж байна. |
| 2.2 | Ковид-19 цар тахлын эрсдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан нэр бүхий 28 албан хаагчид олгосон урамшууллаас ХХОАТ 800.0 мянган төгрөг суутгаагүйг холбогдох ажилтнуудаар төлүүлэх | Урамшуулал хүлээн авсан нэр бүхий албан хаагч нарт зөрчлийг танилцуулсан ба цалингаас зохих суутгалыг хийж, энэ оны 3 дугаар улиралдаа багтаан төлбөрийг бүрэн барагдуулахаар төлөвлөн ажиллаж байна. | Хүлээгдэж байна. |
| 3.Албан шаардлага | | | |
| 3.1 | Эрдэнэцогт сумын ЭМТ-д 3100.0 мянган төгрөгийн үнэтэй хөргөгчийг шийдвэргүйгээр шилжүүлсэнд хөрөнгийн эзэмшигчийг тогтоох шийдвэр гаргаж, зөрчлийг арилгах | Эрүүл мэндийн газрын даргын 2022.06.30-ны өдрийн А/53 дугаар тушаалаар Эрдэнэцогт сумын ЭМТ-д 3100.0 мянган төгрөгийн үнэ бүхий VLS 064RF маркийн хөргөгчийг эзэмшүүлэх шийдвэрийг гаргаж, сумын ЭМТ-д хүргүүлж, албан шаардлагын хэрэгжилтийг хангуулж ажиллаа. | 100 |
| 3.2 | Цалингийн зардлын тулгалтаар 3 ажилтны цалин болох 989.8 мянган төгрөгийг нийгмийн даатгалын санд мэдээлээгүйг нөхөн мэдээлж, зөрчлийг арилгах | Нэр бүхий 3 ажилтны нийт 989.8 мянган төгрөгийн цалин 2022 оны 06 дугаар сард нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд нөхөн мэдээлж, шимтгэлийн тооцоог хийж ажиллаа. | 100 |



Handwritten signature

П.МӨНХ-ЭРДЭНЭ